



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Дүүргийн баяр наадмыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.5, 5.7, 5.8, 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн баяр наадмыг 2025 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.Баяр наадамд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү) нарт зөвшөөрсүгэй.

3.Баяр наадмын бэлтгэл ажлыг сайтар ханган, зохион байгуулалтын явцыг танилцуулж ажиллахыг Салбар хороодын дарга нарт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү хариуцсан салбар хороо (Ц.Мягмарсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

4.Салбар хороодыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, олон нийтийн оролцоог ханган чанар, үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн тайлан мэдээг баяр наадам зохион байгуулж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор танилцуулж ажиллахыг Зохион байгуулах хороо (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД